

Зам, тээврийн хөгжлийн сайдын  
2021 оны 06 дугаар сарын 17.-  
ны өдрийн 17:18:51, албан  
бичгийн хавсралт

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН ГДАМДИННЯМЫН  
ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН САЙД Л.ХАЛТАРТ  
2021 ОНЫ 06 ДУГААР САРЫН 17-НЫ ӨДРИЙН 23 ДУГААРТАЙ  
АЛБАН БИЧГЭЭР ТАВЬСАН АСУУЛТЫН ХАРИУ

**1. Багц 1-1, Багц 1-3, Багц 1-5 дугаар авто замын барилгын ажлыг батлагдсан зураг төсөл, норм, норматив, техникийн баримт бичиг, техник, технологи, эруул ахуй, байгаль орчны болон замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах стандартт, чанарын шаардлыг багц ажил тус бүр хэрхэн биелүүлж гүйцэтгэсэн талаар:**

Азийн хөгжлийн банк /цаашид АХБ гэх/-ны зээлийн хөрөнгөөр хэрэгжиж буй Улаанбаатар-Дархан чиглэлийн 204.11 км авто замын өргөтгөл, шинэчлэлтийн ажлын гүйцэтгэл Багц 1-1 хэсэгт 85.43%, Багц 1-3 хэсэгт 88.34%, Багц 1-5 хэсэгт 90.68% -тай байна.

Зам барилгын ажлын үндсэн ажлын нэг болох асфальтбетон хучилтын ажил Багц 1-1 хэсэгт 2020 онд дууссан, Багц 1-3 хэсэгт 0.8 км, Багц 1-5 хэсэгт 0.33 км тус тус үлдсэн байгаа ба ойрын хугацаанд дуусгах төлөвлөгөөтэй ажиллаж байна.

Төслийн замын зураг төсөл нь Монгол Улсын "Авто зам төсөллөх ЗЗБНБД 22-004-2016" нормыг баримталж, мөрдлөгө болгон боловсруулагдсан бөгөөд холбогдох хууль, журмын дагуу экспертизээр хянагдаж, баталгаажсан болно. Зураг төслийн иж бурдэл нь нарийвчилсан зураг төсөл, техникийн шаардлага, тайлбар бичиг, инженер геологийн судалгааны тайлан, геодезийн судалгааны тайлан зэрэг баримт бичгүүдийг хамарсан.

Зам барилгын ажлын явцад зураг төсөл, техникийн шаардлага, технологи үйл ажиллагаанд өдөр тутмын техник, технологийн хяналт тавих, зевлех үйлчилгээг олон улсын тендерээр шалгарсан БНЭУ-ын "Ай Си Ти" компани болон түүний туслан гүйцэтгэгч Монгол Улсын "Ай Си Ти Сайн Консалтинг" ХХК гүйцэтгэж байна.

Багц тус бүрт хэсгийн ахлагч, замын инженер, гүүр хоолойн инженер, тоо хэмжээний инженер, геодезийн инженер, материалын инженер, нарийн бичиг гэсэн бүрэлдэхүүнтэй зевлехийн баг өдөр тутмын зам барилгын ажилд хяналт тавин ажиллаж байна.

Төслийн зам барилгын ажилд байгаль орчин, эруул ахуйн чиглэлээр 2018 онд боловсруулагдаж Монгол Улсын Засгийн газар болон АХБ хооронд байгуулагдсан зээлийн гэрээний хавсралтад тусгагдан албажсан "Байгаль орчны менежментийн төлөвлөгөө" (5 жилийн); төслийн "Байгаль орчны нелөөллийн нарийвчилсан үнэлгээ" (2019 он) зэрэг баримт бичгүүд мөрдөгдөн ажилласны дээр багц тус бүрт 2019, 2020 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг батлуулж, төлөвлөгөөний биелэлтийг холбогдох журмын дагуу Байгаль орчин, аялал жуулчлалын яаманд тайлагнаж ажилласан.

Авто замын бүтээн байгуулалтын ажлыг саадгүй хэрэгжүүлэх, авто замын трассын дагууд хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах хүрээнд Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн хуралдаанаас тус авто замын барилгын ажлыг гүйцэтгэхэд замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, хяналт тавих

үүрэг бүхий Цагдаагийн гэрээт нэгж ажиллуулах шийдвэр гарсан. Тус нэгж нь 2019 он, 2020 оны барилгын ажлын улиралд тус нэгж төслийн авто зам дагууд хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, осол гэмтлээс урьдчилан сэргийлэх, хяналт тавин үйл ажиллагааг хэрэгжүүлж ажилласан ба 2021 онд үргэлжлүүлж ажиллуулахаар төлөвлөсөн боловч нэгжийн үйл ажиллагааны санхүүжилтийн эх үүсвэрийг шийдвэрлэхэд хүндрэл гарсан үйл ажиллагааг 2021 оны 05 дугаар сарын 30-ны өдрөөр дуусгавар болгосон.

Гэрээт тээврийн цагдаагийн албан хаагчид нь төслийн авто зам дагууд Төв аймгийн Борнуур сумын салдаг уулзвар, Сүмбэр сумын 124-ын даваа, Баянцогт сумын Хайртхаан салдаг уулзварт зэлжийн зохион байгуулалтаар байнгын хяналт тавьж ажилласны дээр зам барилгын ажлын технологи үйл ажиллагаатай уялдуулан шаардлагатай тухайн хэсэг бүрд авто замын хөдөлгөөнийг зохицуулах; авто замаар хөдөлгөөн нээх, хаах тухай бүрд замын дагууд үзлэг шалгалт хийж, хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах зөвлөмж, чиглэлээр хангах; аж ахуйн нэгжүүдэд түр болон үндсэн замын ашиглалтын нехцел байдал, тээврийн хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг хангахад чиглэгдсэн мэдэгдэл, шаардлага тавих; зам барилгын ажлын гүйцэтгэгч байгууллагуудын тээврийн хэрэгслийн жолоочид хөдөлгөөний аюулгүй байдлын сургалт зохион байгуулах; зам тээврийн осол, гэмтлээс урьдчилан сэргийлэх талаар олон нийтэд сурталчлан таниулах зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлсэн.

Төслийн авто зам дагууд хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах хүрээнд барилгын ажлын гэрээнд заасны дагуу багц тус бурийн гүйцэтгэгч байгууллагууд түр замын засвар, арчлалтын ажлыг хариуцан гүйцэтгэж байна. Зам барилгын оргил ачааллын үед түр замын засварын ажлыг зарим тохиолдолд орхигдуулах дутагдал гарч байсан хэдий ч аль болох цаг алдалгүй засвар арчлалтыг гүйцэтгүүлэх үүрэг чиглэл, шаардлагыг тавьж ажилласан.

Өвлийн улиралд түр замаар хөдөлгөөн нэвтрүүлэх боломжгүй /даваа, гүезээтэй хэсэгт халтираа, гулгаа үүсэх эрсдэлтэй/ тул хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах үүднээс төслийн үндсэн авто замын трассаар хөдөлгөөн нээх шаардлагад нийцүүлэн 2019 он, 2020 оны өвлийн улиралд авто замын үндсэн трассаар хөдөлгөөн нээж, өвлийн замын арчлалтыг гүйцэтгүүлсэн.

Зам барилгын ажил дууссаны дараагаар авто замыг байнгын ашиглалтад авах улсын комисс ажиллана. Тус улсын комисст холбогдох журмын дагуу захиалагч, зураг тесел зохиогч, техник технологийн хяналтын зөвлөх, байгаль орчин, тээврийн цагдаа, салбарын мэргэжлийн хяналт, зам хариуцагч буюу авто замын засвар арчлалтын зэрэг байгууллагуудын төлөөлөл орж ажиллах ба тус бүр өөрсдийн байгууллагын чиг үүргийн хүрээнд авто замыг ашиглалтад авах шаардлага хангаж байгаа эсэхэд хяналт тавьж, дүгнэлт гарган эцсийн нэгдсэн дүгнэлт, шийдвэрийг гарна.

Улсын комиссын ажлын үр дүнд тус авто замын барилгын ажил чанар, стандартын шаардлага, байгаль орчин болон хөдөлгөөний аюулгүй байдлын нехцел шаардлага хэрхэн хангагдсан байдал тодорхойлогдож, баталгаажих юм.

**2. Дээрх багц ажлуудын ерөнхий гүйцэтгэгч компаниуд нь туслан гүйцэтгэгчээр ажиллаж байгаа Монгол Улсын аж ахуйн нэгжүүдэд хүндрэл, чирэгдэл үүсгэлгүйгээр гэрээнд заасан хугацаанд санхүүжилтийг олгодог эсэх талаар:**

Зам барилгын ажлын Багц 1-1 хэсэгт туслан гүйцэтгэгчээр 2019 онд "Үйлсийн зам" ХХК болон "Эсто" ХХК, 2020 онд "Эсто" ХХК, "Болорболд зам" ХХК, "Дойч Рөуд"

ХХК тус тус ажилласан. Багц 1-3 хэсэгт туслан гүйцэтгэгч ажиллаагүй. Багц 1-5 хэсэгт "WXP" ХХК ажилласан.

Захиалагч Зам, тээврийн хөгжлийн яам нь барилгын ажлын хугацаанд "Үйлсийн зам" ХХК-иас үндсэн гүйцэтгэгчээс санхүүжилтээ авч чадахгүй байгаа талаарх гомдол хүлээж авсан. Өргөдлийн дагуу тодруулга, тайлбарыг үндсэн гүйцэтгэгч байгууллагаас авсан ба тус туслан гүйцэтгэгчийн гүйцэтгэсэн ажлын зарим хэсэгт гарсан гологдлыг засварласны дараагаар төлбөрийг эцэслэн барагдуулах шаардлага тавигдсан байсан.

Бусад туслан гүйцэтгэгч байгууллагуудаас санхүүжилттэй холбогдох санал, гомдол хүлээж аваагүй болно.

**3. Зам барилгын ажлын Багц 1-1, Багц 1-3, Багц 1-5 дугаарт хийгдсэн авто замыг зам барилгын ажлын Багц 1-2, Багц 1-4 дугаарт хийгдэх авто замаас түрүүлж ашиглалтад авч, тус зам дундаа хоёр тасарч байгаатай холбогдуулах байгаль орчны болон замын хөдөлгөөний аюулгүй байдлыг шаардлагыг хангах хүрээнд авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар:**

Төслийн зам барилгын ажлын Багц 1-1, Багц 1-3, Багц 1-5 хэсгийн үндсэн зам барилгын ажлыг 07 дугаар сарын дундуур дуусах төлөвлөгөөтэй ажиллаж байна. Үндсэн зам барилгын ажил дууссаны дараагаар заслын ажил, тэмдэг, тэмдэглэгээ тавих, тоноглол суурилуулах зэрэг бусад ажлууд үргэлжлэн хийгдэх юм.

Эдгээр авто замын хэсгүүдийг улсын ашиглалт оруулах, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг нээхдээ гэрээний хүрээнд хөдөлгөөний аюулгүй байдлыг бурэн хангуулах арга хэмжээг авна.

Одоогоор Багц 1-2 болон Багц 1-4 хэсэгт авто замын үндсэн трассаар тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг нэвтрүүлж байна. Багц 1-1, Багц 1-3, Багц 1-5 хэсгийн авто зам ашиглалтад оруулах үед багц хэсгүүдийн авто зам холбогдох хэсгүүдэд мэргэжлийн байгууллагын санал, дүгнэлтийг үндэслэн хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах шаардлагатай тэмдэг, тэмдэглэгээ, тоноглолыг тавих арга хэмжээг авна.

Багц 1-2 болон Багц 1-4 хэсгийн барилгын ажил эхлэх үеэр авто замын үндсэн трассыг хэсэгчлэн хаах /ажил хийгдэх хэсэгт/, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг түр замд шилжүүлэх арга хэмжээг авна. Түр замд тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг шилжүүлэхээс өмнө техникийн шаардлагад заасны дагуу түр замын засвар, арчлалтын ажлыг гүйцэтгүүлж, хөдөлгөөн саадгүй, аюулгүй зорчих нехцелийг бурдүүлнэ. Эдгээр багц хэсгүүдэд хамрах авто замын урт 90.58 км бөгөөд АХБ болон ЕСБХБ-ны теслүүдийн гүйцэтгэгч байгууллагууд түр замын арчлалтыг багц тус бүрт хувааж хариуцан ажиллах юм.

Багц 1-1, Багц 1-3, Багц 1-5 хэсгүүдийн ажлыг улсын ашиглалтад хүлээн авахдаа байгаль орчинд тавигдах шаардлагыг бурэн хангуулах ба Багц 1-2 болон Багц 1-4 хэсэгт гэрээ байгуулагдсаны дараагаар гэрээнд заасны дагуу байгаль орчны шаардлагуудыг тавьж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах болно.